

Түүх 6 : Загалмай

Библийн эшлэл
[Лук 24:7]

Хүний Хүү нүгэлт хүмүүсийн гарт тушаагдаж, цовдлогдоод гурав дахь өдөр нь амилах ёстой гэсэн шүү дээ? гэжээ.

Нэгэн өдөр Есүс дагалдагч нарын хамт Гетсемани цэцэрлэг руу явцгаав.

Есүс Бурхан Аавын өмнө өвдөг сөгдөн чин сэтгэлээсээ залбирав. Есүсийг залбирах үед тэнгэр элч нар буун ирж Түүнд хүчийг өгч үйлчлэв. Хэсэг хугацааны дараа, дагалдагч нарын нэг болох Иудас сэлэм агссан цэргүүдтэй хамт ирэв.

Иудас Иерусалимын удирдагч нарт Есүсийг 30 мөнгөн зоосоор зарсан байв. Тэгээд цэргүүдэд ингэж хэлэв.

“Миний үнсэх хүнийг очиж бариарай! Тэр хүн бол Есүс.”

Иудас Есүст ойртон ирж Түүнийг үнсэв. Цэргүүд Есүсийг барин явцгаав.

Есүс баригдаж яваад тахилч нарын өмнө байцаагдав. Эцэст нь ахлах тахилч нар болон ард түмний удирдагч нар Есүсийг алахаар хуйвалдав. Хүмүүс Есүсийн нүүр рүү нулимж Түүнийг цохиж байв.

Дараа өдрийн өглөө нь хүмүүс Есүсийг Пилат захирагчийн өмнө аваачив.

Ахлах тахилч болон удирдагч нар Пилатад Есүсийг нүгэлтэн мэтээр ховлов.

Ингэсэн ч Есүс юу ч хэлсэнгүй. Харин Пилат Есүсийг ямар ч гэм буруугүй болохыг мэдэв. Тухайн үед баяр наадмын үеэр нэг гэмт хэрэгтнийг сулладаг заншил байв.

Заншлын дагуу Пилат ард түмнээс асуув. “Та нар хэнийг суллуулахыг надаас хүсэж байна вэ? Барабыг уу? Есүсийг үү?”

Хүмүүс Барабыг суллахыг шаардаж байв. Бараб бол хүн алж хоригдсон гэмт хэрэгтэн байлаа.

Хүмүүс жагсаал гаргаж үймээн самуун болох вий гэхээс Пилат айж байв.

Эцэст нь Пилат Барабыг суллаж, Есүсийг ташуурдан цовдлох шийдвэр гаргав.

Цэргүүд

Есүст улаан хувцас өмсгөн өргөст титэм толгойд нь зүүлгэж гарт нь хулс атгуулжээ.

Тэгээд Есүсийг өвдөг сөгдүүлэн Түүгээр доог тохуу хийцгээв. Цэргүүд



улаан хувцасыг тайлж Есүст Өөрийнх нь хувцасыг өмсгөв. Загалмайд цовдлохоор Түүнийг чирч гарав.

Есүс Өөрийнхөө цовдлогдох загалмайг үүрэн Голгота толгод өөд явав.

Хүнд модон загалмайг үүрээд явж байсан Есүс чулуунд бүдрэн газарт сөхрөн уначихав.

Цэргүүд эцэст нь тэрүүгээр өнгөрч явсан Симон гэгчид хүчээр загалмайг үүрүүлэн цааш явцгаав.

Есүс Голгота толгод дээр хүрч ирэв. Цэргүүд Есүсийн хувцасыг тайлж нүцгэлэв.

Тэгээд гар болон хөлийг нь маш том хадаасаар модон загалмайд хадаж Түүнийг загалмайд өлгөв.

Цэргүүд Есүсийн хувцасыг хоорондоо шавга хаяж хуваан авав.

Тэд Есүсийг цовдолсон загалмайн тэргүүн хэсэгт “Иудейчүүдийн Хаан” гэж бичсэн пайз хадав.

Зовлон шаналалаа тэвчин Есүс ингэж айлдав.

“Аваа, энэ хүмүүсийг уулчаач. Энэ хүмүүс юу хийж байгаагаа мэдэхгүй байна.”

Хэсэг хугацааны дараа дэлхий хав харанхуйд автав. Гэнэт Есүс загалмай дээрээс ингэж хашгирав.

“Бурхан минь, Бурхан минь, юунд Та Намайг орхив?” Есүс, газар дээр Өөрийнх нь хийх ажил бүгд дууссан гэдгийг мэдэж байв.

Тэгээд намуухан хоолойгоор ингэж хэлэв. “Бүгд биеллээ.”

Есүс ингэж хэлээд нас барав. Яг тэр үед, Иерусалим дахь сүмийн хөшиг дээрээсээ доош хүртэл хоёр хэсэг болон урагдав.



Голгота толгод дээр хүчтэйгээр газар хөдөлж хад чулуу хүртэл бүт үсэрч байв.

Хүмүүсийн гэм нүглийн төлөө Бурханы Хүү Өөрийгөө өргөн нас барсан юм.




Бүтээлч байцгаая 1.

Есүсийн бид бүхний төлөө цовдлогдсон “загалмайг” цаасан нуглаасаар хийгээрэй. Тэгээд Түүний бидэнд хандсан хайранд хэр их талархсан сэтгэлтэй байгаагаа найзуудтайгаа хуваалцаарай. **Хэрэглэгдэх зүйлс: Хайч, цавуу**



Жишээ зураг >



а. Искаротын Иудас нь Есүсийг хэдэн мөнгөн зоосоор зарсан бэ?

б. Пилат, яагаад Есүсийг суллах гэсэн бэ?

с. Матай 27:32-44 эшлэлийг уншаад хариулаарай. Загалмайд цовдлогдсон Есүсийн толгойн хэсэгт хадсан пайзан дээр юу бичсэн байдаг вэ?

● Дараах библийн эшлэлийг уншаад цээжлээрэй. (Лук 24:7)

Хүний Хүү нүгэлт хүмүүсийн гарт тушаагдаж, цовдлогдоод гурав дахь өдөр нь амилах ёстой гэсэн шүү дээ? гэжээ.